

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2024/01/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг:  
erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг:  
tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг:  
davaanyamb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	6-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10-11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....	11-12
3.5 Төсвийн төлөвлөлт гүйцэтгэл.....	12-15
4. Аудитын тайлан .....	18
4.1 Ерөнхий зүйл .....	18
4.2 Материаллаг байдал .....	18
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	19
5. Аудитын илрүүлэлт .....	19
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	19-20

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ТТЗ	Төсвийн Төвлөрүүлэн Захирагч



ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ  
ДАРГА Л.ЭНХЖАРГАЛ ТАНАА

## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.25 № 0/279

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгө дансанд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 7.5 сая төгрөг, шилжүүлэн авсан 35.0 сая төгрөг, бусад эх үүсвэрээс хүлээн авсан 1.6 сая төгрөгийн хөрөнгийг тус тус бүртгэж үндсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн байна.

#### Аудитын гол асуудал

Чандмань-Өндөр сумын ТТЗ нь орон нутгийн төсвийн орлогыг нэр төрлөөр нь 40.1 сая төгрөгөөр, аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 5.4 сая төгрөгөөр, Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 14.3 сая төгрөгөөр тасалсан, Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 19 иргэнтэй холбоотой 71.2 сая төгрөгийн авлагыг бүрэн барагдуулаагүй зөрчил илэрсэн.

#### Бусад асуудлын хэсэг

Чандмань-Өндөр сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө 8 зорилтын 84 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулж, хэрэгжилтийг 88.2 хувьтай биелүүлж ажилласан байна.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай

6724040754

хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

				/Мянган төгрөгөөр/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31	
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		754,573.6	400,894.6	
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	524,521.4	182,182.9	
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	88,357.5	82,942.0	
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	141,694.8	135,769.7	
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,102,893.4	1,115,950.8	
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11а, 11б	28,296.3	146,881.8	
37300	Урт хугацаат зээл		28,296.3	146,881.8	
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	1,074,597.1	969,069.1	
39200	Биет хөрөнгө		988,485.4	883,552.2	
39300	Биет бус хөрөнгө	13	86,111.7	85,516.9	
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		1,857,467.0	1,516,845.4	
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		0.0	48.2	
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	0.0	48.2	
41300	Өглөг	17а, 17б	0.0	48.2	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		1,857,467.0	1,516,797.2	
51	Засгийн газрын хувь оролцоо		1,857,467.0	1,516,797.2	
51100	Засгийн газрын оруулсан капитал		330,172.4	330,172.4	
51200	Хуримтлагдсан үр дүн		1,215,834.6	877,992.8	
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		311,460.0	308,632.0	
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		1,857,467.0	1,516,845.4	

### 2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

				/Мянган төгрөгөөр/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31	
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		1,459,485.4	1,263,160.0	
11	ТАТВАРЫН ОРЛОГО		627,561.3	436,717.6	
110	Орлогын албан татвар		170,145.2	216,408.6	
1100	Хувь хүний орлогын албан татвар		182,774.1	230,576.8	
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-12,628.9	-14,168.1	
113	Хөрөнгийн албан татвар		41,899.0	34,081.1	
118	Бусад татвар, төлбөр, хураамж		415,517.2	186,227.8	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	269,360.1	28,997.4	
120	Нийтлэг татварын бус орлого		266,460.1	18,338.3	
121	Хөрөнгийн орлого		2,900.0	10,659.1	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		562,564.1	797,445.0	
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,006,041.5	1,591,713.5	
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,006,041.5	1,591,713.5	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		949,218.7	1,320,746.3	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		422,178.0	486,545.6	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		53,407.6	60,664.9	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		140,396.2	24,057.3	
2104	Хангамж, бараа материалын зардал		36,456.8	74,279.1	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		106,619.6	95,758.4	

**Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан**

2107	Томилолт, зочны зардал		4,796.9	5,999.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		27,830.6	287,636.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		157,533.1	285,805.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		56,822.8	270,967.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		453,443.9	-328,553.6
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		4,187,261.2	12,116.3
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		-3,733,817.3	-340,669.8

**2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан**

		/Мянган төгрөгөөр/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,253,088.3	1,286,907.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	627,561.3	436,717.6
110	Орлогын албан татвар	170,145.2	216,408.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	182,774.1	230,576.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-12,628.9	-14,168.1
113	Хөрөнгийн албан татвар	41,899.0	34,081.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	415,517.2	186,227.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	18,259.3	10,433.2
1181	Газрын төлбөр	16,336.7	31,550.9
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	380,921.2	144,243.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	62,963.0	52,744.5
120	Нийтлэг татварын бус орлого	60,063.0	42,085.4
121	Хөрөнгийн орлого	2,900.0	10,659.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	562,564.1	797,445.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,084,410.0	1,482,745.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,084,410.0	1,482,745.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	783,270.2	1,168,428.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	422,158.3	486,533.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,312.7	60,728.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	143,487.4	24,549.5
2104	Хангамж, бараа материалын зардал	26,596.2	34,767.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,013.6	7,282.1
2107	Томилолт, зочны зардал	4,796.9	5,999.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,370.5	484,502.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	70,534.6	64,066.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	301,139.8	314,316.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	168,678.3	-195,838.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	13,000.0	7,500.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,000.0	7,500.0
2200	Дотоод эх үүсвэрээр	13,000.0	7,500.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-13,000.0	-7,500.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	-139,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	139,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	155,678.3	-342,338.5
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	368,843.1	524,521.4
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	524,521.4	182,182.9

**2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/Мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,633,456.3	0.0	5,633,456.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-42,172.0	0.0	-42,172.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,591,284.4	0.0	5,591,284.4
9	Тайлант үеийн үр дүн	-3,733,817.3	0.0	-3,733,817.3
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,857,467.0	0.0	1,857,467.0
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,857,467.0	0.0	1,857,467.0
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,828.0	0.0	2,828.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,860,295.1	0.0	1,860,295.1
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-2,828.0	0.0	-2,828.0
19	Тайлант үеийн үр дүн	-340,669.8	0.0	-340,669.8
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,516,797.2	0.0	1,516,797.2

**2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/Мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,702,015.1	1,552,653.1	149,362.0	91.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,531,865.1	1,413,653.1	118,212.0	92.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,211,926.2	1,160,307.4	51,618.8	95.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	505,589.1	486,533.1	19,056.0	96.2
210101	Үндсэн цалин	357,665.3	329,160.4	28,504.9	92.0
210102	Нэмэгдэл	142,923.8	117,830.1	25,093.7	82.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.0	6,783.0	-6,783.0	
210104	Урамшуулал	5,000.0	32,759.6	-27,759.6	655.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,198.9	60,728.6	2,470.3	96.1
210201	Тэтгэврийн даатгал	42,094.7	41,184.8	909.9	97.8
210202	Тэтгэмжийн даатгал	5,276.0	4,865.3	410.7	92.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,220.9	3,892.8	328.1	92.2
210204	Ажилгүйдлийн даатгал	1,055.2	918.8	136.4	87.1
210205	Эрүүл мэндийн даатгал	10,552.1	9,866.9	685.2	93.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	200,482.1	196,140.1	4,342.0	97.8
210301	Гэрэл, цахилгаан	56,782.1	53,198.5	3,583.6	93.7
210302	Түлш, халаалт	138,550.0	142,343.0	-3,793.0	102.7
210303	Цэвэр, бохир ус	5,150.0	598.6	4,551.4	11.6
2104	Хангамж, бараа материалын зардал	34,690.0	34,267.8	422.2	98.8
210401	Бичиг хэрэг	3,300.0	3,123.1	176.9	94.6
210402	Тээвэр, шатахуун	26,500.0	26,509.2	-9.2	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,940.0	2,665.0	275.0	90.7
210404	Ном, хэвлэл	350.0	380.0	-30.0	108.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,600.0	1,590.5	9.5	99.4
2105	Нормативт зардал	2,000.0	2,000.0	0.0	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000.0	2,000.0	0.0	100.0

**Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан**

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,508.6	31,367.5	1,141.1	96.5
210602	Тавилга	1,000.0	1,000.0	0.0	100.0
210604	Урсгал засвар	31,508.6	30,367.5	1,141.1	96.4
2107	Томилолт, зочны зардал	6,000.0	5,999.4	0.6	99.9
210702	Дотоод албан томилолт	6,000.0	5,999.4	0.6	99.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	314,955.6	291,739.3	23,216.3	92.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	311,833.6	289,105.2	22,728.4	92.7
210803	Даатгалын үйлчилгээ	238.0	220.6	17.4	92.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200.0	130.5	69.5	65.2
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55.0	0.0	55.0	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,064.0	718.0	346.0	67.5
210807	Газрын төлбөр	1,565.0	1,565.0	0.0	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,501.9	51,531.7	970.2	98.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,217.3	36,299.4	917.9	97.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,284.6	15,232.3	52.3	99.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	319,938.9	253,345.6	66,593.3	79.2
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	303,470.6	237,020.5	66,450.1	78.1
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	303,470.6	237,020.5	66,450.1	78.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,468.3	16,325.1	143.2	99.1
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,038.3	12,038.3	0.0	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,430.0	4,286.8	143.2	96.8
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	170,150.0	139,000.0	31,150.0	81.7
230001	Эргэж төлөгдөх зээл	170,150.0	139,000.0	31,150.0	81.7
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,702,015.1	1,441,313.6	260,701.5	84.7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	216,470.6	171,470.6	45,000.0	79.2
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	216,470.6	171,470.6	45,000.0	79.2
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	995,294.5	1,233,297.6	-238,003.1	123.9
320001	Орон нутгийн төсвөөс	995,294.5	1,233,297.6	-238,003.1	123.9
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	490,250.0	36,545.4	453,704.6	7.5
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	64,000.0	32,900.6	31,099.4	51.4
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,800.0	3,644.7	-1,844.7	202.5
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	424,450.0	0.0	424,450.0	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	178,438.4	-178,438.4	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	67,098.9	-67,098.9	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	54	54	0	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	0	100.0
610001	Төсвийн байгууллага	2	2	0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26	26	0	100.0
620001	Удирдах ажилтан	9	9	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	12	12	0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	5	5	0	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	26	26	0	100.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10	10	0	100.0

**Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан**

650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТУ)	8	8	0	100.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8	8	0	100.0

**2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Код	Үзүүлэлт	/Мянган төгрөгөөр/ Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,621.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,621.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,621.34
2104	Хангамж, бараа материалын зардал	500.00
210402	Тээвэр, шатахуун	500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,587.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,587.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,534.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,534.34
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	15,621.34
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,621.34
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,771.34
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	350.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

**Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:** Чандмань-Өндөр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжийн хэрэгжилт, хөтөлбөр, төслийн биелэлт зэргийг Засаг даргын дэргэдэх тасаг, алба, албан байгууллага, аж ахуйн нэгжид хэрхэн хэрэгжиж байгааг хянах, шалгах, зохицуулах, чиглэл өгөх, мэдээлэл авах зэрэг эрхтэйгээс гадна дээрх байгууллагаар дамжуулан мэдээллийг цуглуулж хяналт шинжилгээ хийх дүгнэлт гаргах үүрэгтэй ажилладаг орон нутгийн төсвийн захирагч юм.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37-д төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг төсвийн төвлөрүүлэн захирагч гэж заасан байна.

ТТЗ-ийн хяналтад сумын ЗДТГ, ИТХ, сумын ОНХС, Хоршоо хөгжүүлэх сан, сумын төрийн сангийн тайлан нийт 5 төсвийн шууд захирагч, тусгай сангийн тайлан нэгтгэгдэж байна.

Чандмань-Өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант хугацаанд “Олон нийтийн оролцоонд тулгуурласан, ил тод хариуцлагатай засаглалтай иргэдээ дээдэлсэн төрийн үйлчилгээг эрхэмлэн, сумын хөгжил дэвшлийг оновчтой бодлогоор хангана” гэсэн эрхэм зорилго дэвшүүлэн ажилласан байна

Чандмань-Өндөр сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө 8 зорилтын 173 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулж, хэрэгжилтийг 88.2 хувьтай биелүүлж ажилласан байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

**Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:**

ТТЗ нь сумын ЗДТГ, ИТХ, сумын ОНХС, Хоршоо хөгжүүлэх сан, сумын орон нутгийн орлогын тайлан зэргийг хяналтдаа авч ажилладаг байна.

Чандмань-Өндөр сумын ТТЗ нь Төсвийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад хууль тогтоомж журам зааврыг мөрдөн ажилласан байна. Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 36 дугаар зүйлийн 36.6-д заасны дагуу Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/55 дугаар захирамжаар 5 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналтын баг байгуулсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2023 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалт, орон нутгийн орлогын гүйцэтгэл, худалдан авах ажиллагаа, шилэн дансны мэдээлэл, Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олголт, худалдан авах ажиллагаа зэрэг үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Чандмань-Өндөр сумын төсвийн байгууллагуудын Төсвийн талаарх хяналтыг санхүүгийн алба хэрэгжүүлж байна. Бүх ажил гүйлгээг цахимаар гүйцэтгэж байгаа бөгөөд төрийн сангийн төлбөр тооцооны системээр хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна. Төрийн сангийн төлбөр тооцоог цахимаар гүйцэтгэх болсноор анхан шатны баримтыг бүрэн оруулсны дараа ажил гүйлгээ баталдаг тул анхан шатны баримтын бүрдүүлэлт сайжирсан байна.

**Төрийн сангийн дотоод хяналтын талаар:** Аймгийн санхүү төрийн сангийн хэлтсээс Чандмань-Өндөр сумын төрийн сангийн 2023 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 2023 оны 08 дугаар сарын 31-ны өдрийн хоорондох үйл ажиллагаанд хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Тус хяналтаар төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ гаргалт, “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”-ын хэрэгжилт нэмэлт санхүүжилтийн эрх олголт, орлогын хаалт, системийн хяналт, төлбөр тооцооны хяналт, гарын үсгийн баталгаа, дансны бичилтүүд, төсвийн байгууллагын “мөнгөн кассын үйл ажиллагааны журам”-ын хэрэгжилт, баримтын бүрдэл зэрэгт хяналт хийсэн байна.

Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах хугацаатай 3 зөвлөмжийг өгсөн бөгөөд алдаа, зөрчлийг арилгаж ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Дотоод аудит /аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах/ дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2005 оны 341 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах зааврын”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх онд 1,857.5 сая төгрөг байсан бөгөөд 1,516.8 сая төгрөг болж 340.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	524,521.4	182,182.9	-342,338.5
Авлага	88,357.5	82,942.0	-5,415.5
Бараа материал	141,694.8	135,769.7	-5,925.1
Урт хугацаат зээл	28,296.3	146,881.8	118,585.4
Үндсэн хөрөнгө	1,074,597.1	969,069.1	-105,528.0
Нийт хөрөнгө	1,857,467.1	1,516,845.4	-340,621.7
Өр төлбөр	0.0	48.2	48.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,857,467.1	1,516,797.2	-340,669.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,857,467.1	1,516,845.4	-340,621.7

Дээрх хүснэгтээс харахад урт хугацаат зээлийн авлага нэмэгдэж мөнгөн хөрөнгө, бараа материал, авлага, үндсэн хөрөнгө дансны үлдэгдлүүд буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 342.3 сая төгрөгөөр буурсан нь Ерөнхий орлогын дансны үлдэгдэл 115.1 сая төгрөг, ОНХС-ийн үлдэгдэл, 58.9 сая төгрөг, ХХС-ийн үлдэгдэл 8.2 сая төгрөг болж буурсан нь нөлөөлсөн байна.
2. Авлагын үлдэгдэл буурахад Хоршоо хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн авлаг буурсантай холбоотой 82.9 сая төгрөг болсон байна.

3. Бараа материалын дансны үлдэгдэл буурахад төсвийн хөрөнгөөр 158.4 сая төгрөгийн, шилжүүлэн авсан 7.7 сая төгрөгийн бараа материалаар тус тус нэмэгдэж, 91.3 сая төгрөгийн материалыг зарцуулж, 78.6 сая төгрөгийн материалыг шилжүүлж, 2.0 сая төгрөгийн материалыг акталж устгасантай холбоотой бараа материалын үлдэгдэл буурсан байна.
4. ТТЗ-ийн харьяа байгууллагуудын Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,074.6 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 7.5 сая төгрөг, шилжүүлэн авсан 35.0 сая төгрөг, бусад эх үүсвэрээс 1.6 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгийг худалдсан 16.0 сая төгрөг болон тайлант хугацаанд бодогдсон 137.8 сая төгрөгийн элэгдлийн зардал хасагдсан нь үндсэн хөрөнгө буурахад нөлөөлсөн байна.

5. Өр төлбөрийн дансны үлдэгдэл 0.04 сая төгрөгөөр өссөн ИТХ-ын ажилчидтай холбоотой өр төлбөр байна.

#### 6. 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 182.2 сая төгрөг болж, өмнөх оноос 342.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Төрийн сангийн харилцах	524,521.4	182,182.9	-342,338.5
<b>Дүн</b>	<b>524,521.4</b>	<b>182,182.9</b>	<b>-342,338.5</b>

Эх сурвалж: Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдлийн 539.0 сая төгрөг нь төрийн сангийн дансанд байршиж байна. Үүнээс орон нутгийн ерөнхий орлогын дансанд 115.1 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн дансанд 58.8 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн дансанд 8.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Аудитаар мөнгөн хөрөнгийн данстай холбоотой алдаа зөрчил илрээгүй.

#### 3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 82.9 сая төгрөг болж, өмнөх оноос 5.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/ мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.0	99.4	99.4
Зээлийн хүүгийн авлага	9,237.5	11,658.7	2,421.2
Хувь хүмүүст олгосон зээл	79,120.0	71,183.9	-7,936.1
<b>Дүн</b>	<b>88,357.5</b>	<b>82,942.0</b>	<b>-5,415.5</b>

Эх сурвалж: Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэл өмнөх онд 88.4 сая төгрөг байсан бөгөөд зээлийн хүүгийн авлага 2.4 сая төгрөгөөр, ажилчдаас авах авлага 0.1 сая төгрөгөөр нэмэгдэж, хувь хүмүүст олгосон зээлийн авлага 7.9 сая төгрөгөөр буурсан байна.

Аудитын илрүүлэлт: Хоршоо хөгжүүлэх сангийн өмнөх оны үлдэгдлээс 22.4 сая төгрөгийн авлагыг барагдуулсан бөгөөд Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 19 иргэнтэй холбоотой 71.2 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй иргэдийг шүүхэд шилжүүлсэн бөгөөд авлага барагдуулах ажиллагаа шүүхийн шатанд явагдаж байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдлийг бүрэн барагдуулаагүй нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 361 дүгээр тушаалаар баталсан "хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1."орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй байна.

### 3.5.3 Урьдчилгаа

Урьдчилж төлсөн зардал гараагүй байна.

### 3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 135.8 сая төгрөг болж, өмнөх оноос 5.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
			Өсөлт (+),	Бууралт (-)
Бичиг хэргийн материал	384.0	259.0		-125.0
Аж ахуйн материал	197.6	140.6		-57.0
Сэлбэг хэрэгсэл	5,010.1	8,180.1		3,170.0
Түлш, шатах тослох материал	7,906.3	8,832.5		926.3
Бусад хангамжийн материал	125,906.8	110,202.4		-15,704.3
Мал амьтад	2,290.0	8,155.0		5,865.0
<b>Дүн</b>	<b>141,694.8</b>	<b>135,769.7</b>		<b>-5,925.1</b>

Эх сурвалж: Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх онд 141.7 сая төгрөг байсан бөгөөд бичиг хэргийн материалын үлдэгдэл 0.1 сая төгрөгөөр, аж ахуйн материал 0.1 сая төгрөгөөр, бусад хангамжийн материал 15.7 сая төгрөгөөр хасагдаж, сэлбэг хэрэгсэл 3.2 сая төгрөгөөр, Түлш, шатах тослох материал 1.0 сая төгрөгөөр, Мал амьтад 5.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

### 3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны эцсийн үлдэгдэл 146.9 сая төгрөг болж, өмнөх оноос 118.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
			Өсөлт (+),	Бууралт (-)
Хувь хүмүүст олгосон зээл	28,296.3	146,881.8		118,585.4
<b>Дүн</b>	<b>28,296.3</b>	<b>146,881.8</b>		<b>118,585.4</b>

Эх сурвалж: Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл 28.3 сая төгрөг байсан бөгөөд 118.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд Хоршоо хөгжүүлэх сангаас 139.0 сая төгрөгийн зээлийг олгосонтой холбоотой байна.

### 3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 5,814.5 сая төгрөг болж, өмнөх оноос 207.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
			Өсөлт (+),	Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	502,142.8	504,522.5		2,379.7
Авто-тээврийн хэрэгсэл	154,248.7	154,248.7		0.0
Машин тоног төхөөрөмж(компьютер)	331,920.4	334,343.7		2,423.3
Тавилга, аж ахуйн эд хогшил	45,915.1	48,135.1		2,220.0
Зам, гүүрний байгууламж	25,000.0	49,000.0		24,000.0

**Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан**

Бусад үндсэн хөрөнгө	200,335.7	197,485.7	-2,850.0
Программ хангамж	3,285.0	3,285.0	0.0
Бусад биет бус хөрөнгө	83,984.0	83,984.0	0.0
<b>Дүн</b>	<b>6,021,250.3</b>	<b>5,814,039.1</b>	<b>-207,211.2</b>

Эх сурвалж: Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

ТТЗ-ийн харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,021.3 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 7.5 сая төгрөг, шилжүүлэн авсан 35.0 сая төгрөг, бусад эх үүсвэрээс 1.6 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгийг худалдсан 16.0 сая төгрөг болон тайлант хугацаанд бодогдсон 137.8 сая төгрөгийн элэгдлийн зардал хасагдсан нь үндсэн хөрөнгө буурахад нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

Аудитаар үндсэн хөрөнгийн данс бүртгэлтэй холбоотой алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

**3.5.7 Өр төлбөр**

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 0.05 сая төгрөг болж, өмнөх оноос 0.05 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Өр төлбөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)	
Ажилчидтай холбогдсон өглөг	0.0	48.2	48.2	
<b>Дүн</b>	<b>0.0</b>	<b>48.2</b>	<b>48.2</b>	<b>48.2</b>

Эх сурвалж: Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 0.05 сая төгрөгөөр өссөн ИТХ-ын ажилчидтай холбоотой өр төлбөр байна.

**3.5.10 Засгийн газрын хувь оролцоо**

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,516.8 сая төгрөг болж, өмнөх оноос 340.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)	
Засгийн газрын оруулсан капитал	330,172.4	330,172.4	0.0	
Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	330,172.4	330,172.4	0.0	
Хуримтлагдсан үр дүн	1,215,834.7	877,992.9	-337,841.8	
Өмнөх үеийн үр дүн	4,949,652.0	1,218,662.7	-3,730,989.3	
Тайлант үеийн үр дүн	-3,733,817.3	-340,669.8	3,393,147.5	
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	311,460.0	308,632.0	-2,828.0	
Засгийн газрын оруулсан капитал	330,172.4	330,172.4	0.0	
<b>Дүн</b>	<b>1,857,467.1</b>	<b>1,516,797.2</b>	<b>-340,669.8</b>	

Эх сурвалж: Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

**Орлогын данс**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт 1,779.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж тайлагнасан байна. Тайлант онд бүрдүүлсэн орлогыг өмнөх онтой харьцуулахад 607.3 сая төгрөгөөр буюу 48.1 хувиар өссөн байна.

Хүснэгт № 9. Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт орлого

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	/мянган төгрөгөөр/ зөрүү	
			Хувь	
Татварын орлого	627,561.3	436,717.6	-190,843.7	69.6
Татварын бус орлого	269,360.1	28,997.4	-240,362.7	10.8
Тусламж санхүүжилтийн орлого	562,564.1	797,445.0	234,880.9	141.8

<b>Нийт дүн</b>	<b>1,489,485.4</b>	<b>1,263,159.9</b>	<b>-226,325.5</b>	<b>84.8</b>
-----------------	--------------------	--------------------	-------------------	-------------

Нийт орлого 226.3 сая төгрөгөөр буурахад өмнөх онд самын орлого ихээр төвлөрсөн, бөгөөд тайлант самрын орлого буурсантай холбоотой байна.

Тусламж санхүүжилтийн орлого 234.9 сая төгрөгөөр нэмэгдсэн тайлант онд албан хаагчдын цалин хөлсний доод хэмжээ, бараа материалын үнэ нэмэгдсэн зэргээс шалтгаалан байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 1,144.7 сая төгрөгийн орлогын давхардсан 7 гүйлгээ, мөнгөн гүйлгээний тайланд 1,298.2 сая төгрөгийн орлогын давхардсан 9 гүйлгээ устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

### Зардлын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаар тайлант онд 1,591.7 сая төгрөгийн үйл ажиллагааны зардлыг хүлээн зөвшөөрч тайлагнасан байна. Өмнөх онтой харьцуулахад 585.7 сая төгрөгөөр буюу 41.8 хувиар өссөн байна.

Хүснэгт № 10. Санхүүгийн үр дүнгийн нийт зардал

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	/мянган төгрөгөөр/	
			зөрүү	Хувь
Бараа ажил үйлчилгээний зардал	949,218.7	1,320,746.3	371,527.6	139.1
Урсгал шилжүүлэг	56,822.8	270,967.2	214,144.4	476.9
<b>Үйл ажиллагааны зардлын дүн</b>	<b>1,006,041.5</b>	<b>1,591,713.5</b>	<b>585,672.0</b>	<b>158.2</b>
<b>Үйл ажиллагааны бус зардал</b>	<b>4,187,261.2</b>	<b>12,116.3</b>	<b>-4,175,144.9</b>	<b>0.3</b>

Эх сурвалж: Чандмань-Өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Үйл ажиллагааны зардлын дүн өссөн нь цалин хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэн болон бараа үйлчилгээний зардлын дүн нэмэгдсэн зэрэг нь нөлөө үзүүлсэн байна.

Үйл ажиллагааны бус зардлын дүн буурсан нь өмнөх онд Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвүүд улсын төсөвт шилжиж үндсэн хөрөнгө, бараа материалыг шилжүүлэн бөгөөд тайлант оны үйл ажиллагааны бус зардлын дүн 4,175.1 сая төгрөгөөр буюу 99.7 хувиар буурсан байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 1,144.7 сая төгрөгийн зардлын давхардсан 7 гүйлгээ, мөнгөн гүйлгээний тайланд 1,298.2 сая төгрөгийн зардлын давхардсан 9 гүйлгээ устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны төсвийн төслийг харьяа байгууллагуудын хүрээнд нэгтгэн боловсруулж орон нутгаас санхүүжүүлэх Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн байгууллагуудын тогтмол зардлыг тусгаж дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн нийт зардлыг 1,542.7 сая төгрөгөөр төлөвлөсөн байна. Уг төсвийн санал дээр 127.8 сая төгрөгийг хасаж 1,414.9 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төслийг боловсруулахдаа Хошоо хөгжүүлэх сангийн зээлийг төлөвлөөгүйтэй холбоотой байна.

Чандмань-Өндөр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 02 дугаар тогтоолоор сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 1,414.9 сая төгрөгийн төсөв баталснаас 972.1 сая төгрөгийг бараа үйлчилгээний зардалд, 272.7 сая төгрөгийг урсгал зардалд, Эргэж төлөгдөх зээлийн зардалд 170.1 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 378.7 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, санхүүгийн дэмжлэгээс 782.7 сая төгрөгийг, сумын орон нутгийн орлогоос 449.2 сая төгрөгийг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 90.9 сая төгрөгийг, давсан орлого дансны үлдэгдлээс 108.8 сая төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Тайлант онд Чандмань-Өндөр сумын ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 24-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор төсөвт 287.1 сая төгрөгийн нэмэх тодотгол хийж төсвийг 1,702.0 сая төгрөгөөр баталсан байна.

### 3.6.2 Төсвийн орлогын гүйцэтгэл

**Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан**

Эх үүсвэрийг 1,702.0 сая төгрөгөөр төлөвлөж, 1,441.3 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 84.7 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс: Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн хүү болон эргэн төлөлтөөс 36.5 сая төгрөгийн орлогыг, ОНХС-аас 171.5 сая төгрөгийг, орон нутгийн төсвөөс 1,233.3 сая төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлсэн байна.

**Сумын төсвийн орлого бүрдүүлэлт.**

Чандмань-Өндөр сумын ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 24-ны өдрийн 01 дүгээр тогтоолд зааснаар Чандмань-Өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 422.9 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна. Гүйцэтгэлээр 452.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 30.0 сая төгрөгөөр буюу 7.1 хувиар давуулан биелүүлсэн байна.

**Хүснэгт № 11. Төвлөрүүлэх орлого**

	/мянган төгрөгөөр/			
<b>Үзүүлэлт</b>	<b>Төлөвлөгөө</b>	<b>Гүйцэтгэл</b>	<b>Зөрүү</b>	<b>Хувь</b>
<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>418,912.6</b>	<b>436,717.6</b>	<b>17,805.0</b>	<b>104.3</b>
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	180,000.0	207,460.4	27,460.4	115.3
Үйл ажиллагааны орлого	5,000.0	2,588.5	-2,411.5	51.8
Хөрөнгийн орлого	15,000.0	14,924.2	-75.8	99.5
Хөрөнгө борлуулсны орлого	540.6	1,279.0	738.4	236.6
Шууд бус орлого	7,000.0	4,324.7	-2,675.3	61.8
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-14,168.1	-14,168.1	0.0	100.0
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	10,000.0	5,749.1	-4,250.9	57.5
Бууны албан татвар	3,000.0	2,642.2	-357.8	88.1
Малд ногдуулах албан татвар	25,000.0	25,689.8	689.8	102.8
Улсын тэмдэгтийн хураамж	6,000.0	4,511.2	-1,488.8	75.2
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	500.0	634.0	134.0	126.8
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	5,202.0	5,288.0	86.0	101.7
Газрын төлбөр	10,500.5	31,550.9	21,050.4	300.5
Дуудлага худалдаа	2,030.0	0.0	-2,030.0	0.0
Ойн нөөц ашигласны төлбөр	157,838.6	131,112.8	-26,725.8	83.1
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	2,352.0	2,352.0	0.0	100.0
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	817.0	2,379.0	1,562.0	291.2
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	2,300.0	8,400.0	6,100.0	365.2
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,000.0</b>	<b>16,199.1</b>	<b>12,199.1</b>	<b>405.0</b>
Торгуулийн орлого	4,000.0	5,540.0	1,540.0	138.5
Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	0.0	10,659.1	10,659.1	
<b>Орлогын дүн</b>	<b>422,912.6</b>	<b>452,916.7</b>	<b>30,004.1</b>	<b>107.1</b>

Эх сурвалж: Чандмань-Өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Чандмань-Өндөр сумын орон нутгийн орлого 30.0 сая төгрөгөөр давж биелэхэд Цалин хөлс, шагнал урамшууллын орлого 27.5 сая төгрөгөөр, газрын төлбөрийн орлого 21.0 сая төгрөгөөр, Хөрөнгө борлуулсны орлого 10.7 сая төгрөгөөр, байгалийн ургамлын нөөц ашигласны орлого 6.1 сая төгрөгөөр давж биелсэн нь нөлөөлсөн байна.

**Илрүүлэлт:** Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл:

Үйл ажиллагааны орлого 2.4 сая төгрөгөөр, хөрөнгийн орлого 0.1 сая төгрөгөөр, шууд бус орлого 2.7 сая төгрөгөөр, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлого 4.3 сая төгрөгөөр, бууны албан татвар 0.4 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 1.5 сая төгрөгөөр, дуудлага худалдааны орлого 2.0 сая төгрөгөөр, ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 26.7 сая төгрөгөөр нийт 40.1 сая төгрөгөөр тасалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцээгүй бөгөөд Эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлж ажиллах зөвлөмж өгөх.

**Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын талаар:** Тайлант онд аймагт төвлөрүүлэх орлогыг 19.1 сая төгрөгөөр төлөвлөж 16.8 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 2.2 сая төгрөгөөр буюу 11.8 хувиар орлогын төлөвлөгөөг тасалсан байна.

Хүснэгт № 12: Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
1	Авто тээвэр болон ӨЯХАТ	10,000.0	12,232.7	2,232.7	122.1
2	Зам ашигласны төлбөр	3,200.0	4,140.0	940.0	129.4
3	Газрын дуудлага худалдаа	870.0	0	(870.0)	0
4	Аж ахуй нэгжийн ОАТ	5,000.0	452.8	(4,547.2)	9.1
<b>Нийт дүн</b>		<b>19,070.0</b>	<b>16,825.5</b>	<b>(2,244.5)</b>	<b>88.2</b>

Эх сурвалж: Чандмань-Өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

**Илрүүлэлт:** Орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл: Газрын дуудлага худалдааны орлогыг 0.9 сая төгрөгөөр, аж ахуй нэгжийн орлогын албан татварын орлогыг 4.5 сая төгрөгөөр нийт 5.4 сая төгрөгөөр тасалсан байна. Орлогыг бүрэн төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцээгүй бөгөөд Эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлж ажиллах зөвлөмж өгөх.

**Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын талаар:** Тайлант онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 17.0 сая төгрөгөөр төлөвлөж 3.2 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж, 13.8 сая төгрөгөөр тасалсан байна.

Хүснэгт № 13: Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	7,074.2	811.6	-6,262.6	11.5
2	Дотоод бараа үйлчилгээний НӨАТ	8,857.9	901.8	-7,956.1	10.2
3	Агаарын бохирдлын төлбөр	1,040.0	1457.2	417.2	140.1
<b>Нийт дүн</b>		<b>16,972.2</b>	<b>3,170.5</b>	<b>-13,801.7</b>	<b>18.7</b>

Эх сурвалж: Чандмань-Өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга.

**Илрүүлэлт:** Орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл: Аж ахуй нэгжийн орлогын албан татварын орлогыг 6.3 сая төгрөгөөр, дотоодын бараа үйлчилгээний НӨАТ-ын орлогыг 8.0 сая төгрөгөөр нийт 14.3 сая төгрөгөөр тасалсан байна. Орлогыг бүрэн төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцээгүй бөгөөд Эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлж ажиллах зөвлөмж өгөх.

#### Үйл ажиллагааны мөнгөн орлогын талаар

Тайлант онд үйл ажиллагааны орлогыг 1,702.0 сая төгрөгөөр төлөвлөж, 1,441.3 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 84.7 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс: Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн хүү болон эргэн төлөлтөөс 36.5 сая төгрөгийн орлогыг, ОНХС-аас 171.5 сая төгрөгийг, орон нутгийн төсвөөс 1,233.3 сая төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлсэн байна.

#### Төсвийн зарлагын талаар:

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 1,702.0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,211.9 сая төгрөгийг бараа ажил үйлчилгээний зардалд, 319.9 сая төгрөгийг урсгал шилжүүлгийн зардалд, 170.2 сая төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хаасан цэвэр зээлийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр урсгал зардалд 253.3 сая төгрөгийг, бараа ажил үйлчилгээний зардалд 1,160.3 сая төгрөгийг, эргэж төлөгдөх зээлд 139.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,552.7 сая төгрөг буюу 91.2 хувьтай байна. Төсвийн хэмнэлтийг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 19.1 сая төгрөг
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 2.5 сая төгрөг
- Байр ашиглалттай холбоотой зардал 4.3 сая төгрөг
- Хангамж, бараа материалын зардал 0.4 сая төгрөг
- Урсгал засварын зардал 1.1 сая төгрөг
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 23.2 сая төгрөг
- Бараа үйлчилгээний бусад зардал 0.9 сая төгрөг
- Урсгал шилжүүлгийн зардал 66.6 сая төгрөг
- Хөрөнгийн зардал 3.6 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх 26 төсөл арга хэмжээнд 303.5 сая төгрөг батлагдсанаас 22 төсөл арга хэмжээнд 237.0 сая төгрөгийг зарцуулж 33.5 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна. Энэ нь мал үзлэгийн хашаа барих ажил хийгдээгүй, Хөцөө засварлах, 3.5 сая төгрөг, Зуны цэцэрлэгийн байр барих 5.0 сая төгрөг, хүүхдэд ээлтэй багш хөтөлбөрийн 15.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлууд дараа онд шилжиж хөрөнгө оруулалтын ажлууд тул гүйцэтгэл гараагүй байна.

Сумын Засаг даргын хөтөлбөрийн хэрэгжилт 1,752.3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 79.5 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ТТЗ-ийн харьяа байгууллагууд нь Засаг даргын нөөц сангаас 0.5 сая төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 14.8 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 0.4 сая төгрөг нийт 15.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Гүйцэтгэлээр шатахууны зардалд 0.5 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 12.5 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 12.5 сая төгрөг нийт 15.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

2023 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

#### **Худалдан авах ажиллагааны үр дүнгийн талаар**

Тайлант онд Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн багцад нийт 861.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 63 бараа ажил үйлчилгээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажилласан байна. Худалдан авах ажиллагааг зохион байгуулж нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 1, харьцуулалтын аргаар 6 тендер шалгаруулалтыг зохион байгуулж 56 ажил үйлчилгээнд шууд гэрээ байгуулж худалдан авалт хийсэн байна. Худалдан авах ажиллагааны үр дүнд 95.9 сая төгрөгийн хэмнэлт гаргаж ажилласан бөгөөд гүйцэтгэл 95.2 хувьтай байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг ТТЗ-ийн 2023 оны төсөвтэй хамт батлуулсан байна.

Тайлант ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 20.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 нэр төрлийн ажлыг шинээр нэмж, 2 төсөл арга хэмжээнд 20.0 сая төгрөгийн төсвийг нэмж, нийт 40.6 сая төгрөгийн тодотголыг хийсэн байна. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 26 төсөл арга хэмжээний 23.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл арга хэмжээ нь дараа онд шилжих өгөөд 10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй мөл үзлэгийн хашаа барих ажил нь малын тоо толгойн албан татварын орлого тасарснаас шалтгаалан хэрэгжээгүй байна.

Тайлант онд худалдан авсан бараа ажил үйлчилгээ нь Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуультай нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримтлан ажилласан байна.

#### 4. АУДИТЫН ТАЙЛАН

##### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Давааням гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар хэрэгжүүлсэн.

Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн 1/29 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

##### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2.0 хувиар тогтоож сонгосон суурь үзүүлэлтээс тооцож 103.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 83.1 сая төгрөгөөр тогтоосон.

Өмнөх онд Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвүүд улсын төсөвт шилжсэнтэй холбоотой үйл ажиллагааны бус зардлын дүн өндөр байсантай холбоотой тайлант оны нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн өмнөх оноос материаллаг хэмжээгээр буурсан тул Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшнийг тайлант оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 1,603.1 сая төгрөгийг сонгож 25.7 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

##### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Харьяа байгууллагын зөрчлийн талаар:

- Чандмань-Өндөр сумын ИТХ-ын төсвөөс 0.5 төгрөгийг бэлэг дурсгалын зүйлд зарцуулсан.
- Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдийг чадавхжуулах сургалтад хамруулахаар 1 төлөөлөгчид 0.5 сая төгрөгөөр тооцож 20 төлөөлөгчийн сургалтын зардалд Азийн Эдү Гүүр ХХК-д 10.6 сая төгрөгийг шилжүүлэн 17 хүнийг сургалтад хамруулсан байна. 2023 оны 12 дугаар сарын байдлаар Азийн эдү гүүр ХХК-тай тооцоо нийлсэн актаар өглөг авлага байхгүй бөгөөд 1.6 төгрөгийн зардал нь анхан шатны баримтаар нотлогдохгүй байна

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах 16 дугаар зүйлийн 16.5.5."батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5."төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах"-ыг хориглоно, Төсвийн тухай хуулийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй тул төлбөрийн акт тогтоосон.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан бөгөөд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

ТТЗ-ийн худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй. Худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглан бага үнийн санал ирүүлсэн байгууллагуудтай гэрээ хийж бараа материалыг худалдан авсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 онд гүйцэтгэх завсрын үеийн санхүүгийн аудитын төлөвлөгөөнд тус байгууллагыг хамруулаагүй тул завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудит хийгээгүй болно

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 121.1 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмжийг өгсөн байна.

Хүснэгт № 14 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	4	121,100.0	4	121,100.0	100
Нийт дүн	4	121,100.0	4	121,100.0	100

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 121.1 сая төгрөгийн 4 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал илрээгүй болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 2 төсвийн байгууллага, 2 санг түүвэрт хамруулан үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн байна.

Чандмань-Өндөр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн нийт 131.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байх 2 зөвлөмжийг өгсөн.

Чандмань-Өндөр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар 2.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Илэрсэн зөрчилд 2.1 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоосон.

Чандмань-Өндөр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар 2.1 сая төгрөгийн материаллаг зөрчил илэрсэн бөгөөд тогтоосон материаллаг түвшнээс хэтрээгүй тул зөрчилгүй дүгнэлт өгсөн болно.

## 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарах асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй холбоотой асуудлын талаар

Илрүүлэлт: Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 19 иргэнтэй холбоотой 71.2 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021оны 361 дүгээр тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1."орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг бүрэн барагдуулж ажиллах

### 2. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Орон нутгийн төсвийн орлогыг нэр төрлөөр нь 40.1 сая төгрөгөөр, аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 5.4 сая төгрөгөөр, Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 14.3 сая төгрөгөөр нийт 58.9 сая төгрөгөөр тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцээгүй бөгөөд "Эрх үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлэх.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5."Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орлого бүрдүүлэлттэй холбоотой	1	59.8					1	59.8				
Хугацаа хэтэрсэн зээлийн авлага	1	71.2					1	71.2				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>131.0</b>					<b>2</b>	<b>131.0</b>				
<b>Иргэдийн Төлөөлөгчдийн хурал</b>												
Сургалтад анхан шатны баримтаар нотлогдохгүй зардал гаргасан	1	1.6	1	1.6								
Төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан	1	0.5	1	0.5								

#### АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

БАТАЛГААЖУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР

Б.ДАВААНЫМ ОГНОО: